



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 19 сарын 03 өдөр

Дугаар 18

Дархан сум

Аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэл,
2026 оны төсөв батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.1.3, 35 дугаар зүйлийн 35.1.9, 48 дугаар зүйлийн 48.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, 8 дугаар зүйлийн 8.5.2, 57 дугаар зүйлийн 57.2, 61 дүгээр зүйлийн 61.4, 64 дүгээр зүйлийн 64.1.2, 64.1.3, 68 дугаар зүйлийн 68.1, 68.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн 2024 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг 100,311,474.9 мянган төгрөг, төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг 81,541,297.4 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

Хоёр. 2026 оны төсвийн жилд аймгийн төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

(мянган төгрөг)

Д/д	Байгууллага, орлогын нэр төрөл	Дүн
1.1	Аймгийн төсвийн татварын орлого	11,525,000.0
	1.1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	12,020,000.0
	1.1.2. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,710,000.0
	1.1.3. Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	495,000.0
	1.1.4. Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-5,000,000.0
	1.1.5. Улсын тэмдэгтийн хураамж	2,300,000.0
1.2	Аймгийн төсвийн татварын бус орлого	5,800,000.0
	1.2.1. Хүү, торгуулийн орлого	2,100,000.0
	1.2.2. Хүүгийн орлого	2,500,000.0

452501044

1.2.4	Хууль тогтоомжийн дагуу аймгийн төсөвт төвлөрүүлэх бусад орлого	1,200,000.0
Нийт дүн		17,325,000.0

Гурав. 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх өөрийн орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

(мянган төгрөг)

Д/д	ТӨЗ, түүний харьяа байгууллага	Орлогын дүн
2.1	Засаг дарга	914,000.0
2.1.1	Аймгийн ЗДТГ	75,000.0
2.1.2	Орон нутгийн хүүхдийн зуслан	759,500.0
2.1.3	Аймаг хотын театр чуулга	10,000.0
2.1.4	Биеийн тамир спортын газар	15,000.0
2.1.5	Гэрлэх ёслолын ордон	31,000.0
2.1.6	Ахмадын хөгжлийн төв	8,500.0
2.1.7	Нэгдсэн эмнэлэг	15,000.0

Дөрөв. 2026 оны төсвийн жилд зарцуулах урсгал зарлагын нийт хэмжээг 34,932,347.5 мянган төгрөгөөр баталж, ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

/мянган төгрөг/

Д/д	Төсвийн захирагч	Зардлын дүн
3.1.	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Урсгал зардал	3,378,432.7 3,378,432.7
	3.1.1. Иргэдийн төлөөлөгчдийн Хурал урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага) хөтөлбөр 2 (Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх) хөтөлбөр 3 (Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх)	1,576,432.7
		1,531,000.0
		271,000.0
3.2.	Засаг дарга Урсгал зардал	31,553,914.8 31,553,914.8
	3.2.1 АЗДТГазар урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага) хөтөлбөр 2 (орон нутгийн нөөц сан)	7,932,684.8
		6,832,684.8
	3.2.2 Хотын захирагчийн алба урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага)	1,100,000.0
		565,162.90
3.2.3 Санхүүгийн хяналт, аудитын газар урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага)	565,162.90	
		645,716.0
		645,716.0

3.2.4	Худалдан авах ажиллагааны газар урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Худалдан авах ажиллагаа)	517,258.4 517,258.4
3.2.5	Орон нутгийн өмчийн газар урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх)	488,456.2 488,456.2
3.2.6	Байгаль орчныг хамгаалах газар урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага)	681,158.4 681,158.4
3.2.7	Сум дундын ойн анги урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Ойжуулалт)	230,709.1 230,709.1
3.2.8	Орон нутгийн ахмад настны кабинет төв /Ахмадын хөгжлийн төв/ урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Ахмад настны хөгжил хамгаалал)	1,319,304.3 1,319,304.3
3.2.9	Орон нутгийн Ахмадын хороо урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Ахмад настны хөгжил хамгаалал)	334,994.9 334,994.9
3.2.10	Махны нөөц урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага)	366,000.0 366,000.0
3.2.11	Өвс, тэжээлийн нөөц урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага)	132,300.0 132,300.0
3.2.12	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Мал аж ахуйг хөгжүүлэх)	124,217.1 124,217.1
3.2.13	Аймгийн халамжийн сан урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Нийгмийн халамж) хөтөлбөр 2 (Нийгмийн халамж) Нарны хүүхдүүд	574,303.7 230,482.7 343,821.0
3.2.14	Хотын нийтийн хүн тээвэр урсгал зардал, үүнээс хөтөлбөр1 (Хүүхдийн хөгжил хамгаалал) хөтөлбөр1 (Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр)	4,597,609.5 714,182.0 3,883,427.5
3.2.15	Улсын төсвийн байгууллагуудад орон нутгийн нэмэгдэл 40% урсгал зардал, үүнээс: хөтөлбөр1 (орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага)	3,845,324.3 3,845,324.3
3.2.16	Дархан орон нутгийн зам тээвэр (Санхүүгийн дэмжлэг) урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Авто зам)	1,100,000.0 1,100,000.0

3.2.17	Мэдээлэл, технологийн алба	610,015.0
	урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Орон нутгийн хэвлэл мэдээлэл)	610,015.0
3.2.18	Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ	280,010.9
	урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага)	280,010.9
3.2.19	Татварын хэлтсийн тээврийн тасаг	5,300.0
	урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Авто зам)	5,300.0
3.2.20	Орон нутгийн хүүхдийн байгууллага	980,939.8
	урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Хүүхдийн хөгжил, хамгаалал) Хүүхдийн зуслант амралт	759,500.0
	хөтөлбөр 2 (Гэр бүлийн хөгжил, хамгаалал) Хуримын ордон	221,439.8
3.2.21	Биеийн тамир, спортын газар байр ашиглалтын зардал	1,545,078.3
	урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Биеийн тамир, спорт)	1,545,078.3
3.2.22	Аймаг, хотын театр чуулга байр ашиглалтын зардал	205,028.2
	урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Соёл урлаг)	205,028.2
3.2.23	Мэргэжлийн боловсролын байр ашиглалтын зардал	806,724.1
	урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Мэргэжлийн боловсрол)	806,724.1
3.2.24	Нэгдсэн эмнэлгийн байр ашиглалтын зардал	1,064,164.8
	урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Эрүүл мэнд)	1,064,164.8
3.2.25	Засаг дарга	2,601,454.1
	урсгал зардал, үүнээс: хөтөлбөр 1 (Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх)	2,601,454.1

Тав. 2026 оны төсвийн жилд аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 4,454,812.8 мянган төгрөг, шилжих төсөл арга хэмжээг 4,346,227.2 мянган төгрөг, их засварын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 2,411,657.0 мянган төгрөг, шилжих төсөл арга хэмжээг 849,427.7 мянган төгрөг, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 2,779,676.0 мянган төгрөг, шилжих төсөл арга хэмжээг 1,280,962.2 мянган төгрөг, байгаль орчны нөхөн сэргээх төсөл арга хэмжээний зардлын хэмжээг 510,917.3 мянган төгрөг, шилжих төсөл арга хэмжээг 285,378.3 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжих төсөл арга хэмжээг 1,788,150.9 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

Зургаа. 2026 оны төсвийн жилд аймгийн төсвөөс сумдын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

(мянган төгрөг)

Д/д	Сум (дүүрэг)-ын нэр	Дүн
1.	Орхон сум	2,233,946.3
2.	Шарын гол сум	1,956,865.7

	Нийт дүн	4,190,812.0
--	-----------------	--------------------

Долоо. 2026 оны төсвийн жилд сумдын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

(мянган төгрөг)

Д/д	Сум (дүүрэг)-ын нэр	Дүн
1.	Дархан сум	36,635,893.9
2.	Хонгор сум	7,988,815.6
	Нийт дүн	44,624,709.5

Найм. Аймгийн төсвөөс 2026 оны төсвийн жилд Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 10,872,400.0 мянган төгрөгөөр баталсугай.

Ес. Аймгийн 2026 оны орон нутгийн хөгжлийн сангаас сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай:

(мянган төгрөг)

Д/д	Аймаг (нийслэл)-ийн ОНХСан нийт	Дүн
9.1	Аймаг (нийслэл)-ийн ОНХС	4,597,396.7
9.1.1	Орон нутгийн төсөвт үлдэх хувь хэмжээгээр тооцсон дүн [1]	4,597,396.7
9.2	Нийт сумдад хуваарилах дүн	7,988,961.5
9.2.1	Сум 1 (Дархан сум)	2,365,583.5
9.2.1.1	Итгэлцүүрээр хуваарилагдсан хөрөнгө	2,065,385.5
9.2.1.2	ОНХС-ийн гүйцэтгэлийн урамшуулал	299,209.5
9.2.1.3	АМНАТ (мега/, АМ-ын хайгуулын болон ашиглалтын зөвшөөрлийн төлбөр)	988.5
9.2.2	Сум 2 (Орхон сум)	438,145.8
9.2.2.1	Итгэлцүүрээр хуваарилагдсан хөрөнгө	437,781.4
9.2.2.2	ОНХС-ийн гүйцэтгэлийн урамшуулал	
9.2.2.3	АМНАТ (мега/, АМ-ын хайгуулын болон ашиглалтын зөвшөөрлийн төлбөр)	364.4
9.2.3	Сум 3 (Хонгор сум)	3,760,220.7
9.2.3.1	Итгэлцүүрээр хуваарилагдсан хөрөнгө	3,228,566.5
9.2.3.2	ОНХС-ийн гүйцэтгэлийн урамшуулал	480,670.3
9.2.3.3	АМНАТ (мега/, АМ-ын хайгуулын болон ашиглалтын зөвшөөрлийн төлбөр)	50,983.9
9.2.4	Сум 4 (Шарын гол сум)	1,425,011.5
9.2.4.1	Итгэлцүүрээр хуваарилагдсан хөрөнгө	1,164,361.7
9.2.4.2	ОНХС-ийн гүйцэтгэлийн урамшуулал	238,811.0
9.2.4.3	АМНАТ (мега/, АМ-ын хайгуулын болон ашиглалтын зөвшөөрлийн төлбөр)	21,838.8
	Нийт	12,586,358.2

Арав. Монгол улсын төсөвт 2026 онд дор дурдсан зээлийн эргэн төлөх үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр төлсүгэй.

№	Төслийн нэр	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр
1	Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл (АХБ 3245МОН)		2,711,086.9

Арван нэг. Аймгийн 2026 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг **76,011,252.5** мянган төгрөг буюу дор дурдсанаар баталсугай:

1. Аймгийн татварын болон татварын бус орлого 18,239,000.0 мянган төгрөг;
2. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 4,597,396.7 мянган төгрөг;
3. Сумдын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 44,624,709.5 мянган төгрөг;
4. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн урьд оны үлдэгдэл 1,788,150.9 мянган төгрөг;
5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын урьд оны үлдэгдэл 4,346,227.2 мянган төгрөг;
6. Орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх урьд оны үлдэгдэл 1,280,962.2 мянган төгрөг;
7. Орон нутгийн их засварын хөрөнгө оруулалтын урьд оны үлдэгдэл 849,427.7 мянган төгрөг;
8. Байгаль орчны нөхөн сэргээх төсөл арга хэмжээний зардлын урьд оны үлдэгдэл 285,378.3 мянган төгрөг;

Арван хоёр. “Аймгийн 2026 оны төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Арван гурав. “Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Арван дөрөв. “Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

Арван тав. “Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

Арван зургаа. “Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 5 дугаар хавсралтаар баталсугай.

Арван долоо. “Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын жагсаалт”-ыг 6 дугаар хавсралтаар баталсугай.

Арван найм. Аймгийн Засаг дарга (Б.Азжаргал)-д даалгах нь:

1. Аймгийн 2026 оны төсөвт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөөс гарсан саналыг тусган хэрэгжүүлж, батлагдсан төсвийн орлого, зарлагыг жигд ханган биелүүлж, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2026 оны төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлэх.

Арван ес. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



А.ЯНЖМАА

А.ЯНЖМАА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
18 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ЗАХИРАГЧ НАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨР,
ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЧАНАРЫН БОЛОН ТОО ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Хөтөл бөрий н код	Төсвийн хөтөлбөр	Хөтөлбөрийн хүрэх үр дүн	Үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлт	Хэмж их нэгж	Суурь он	Суурь түвшин	2026 оны зорилгот түвшин	Хөтөлбөрийн зарцуулах төсөв (сая.төг)
1. Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга									
3,378.4									
1.1	70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	ИТХ-ын ээлжит, ээлжит бус хуралдааныг зохион байгуулж, хэлэлцэх асуудлыг бүрэн шийдвэрлэж, тогтоол шийдвэр гаргах	Шийдвэрлэх асуудал, тоо, хурлын тогтоол, тоо	тоо	2025	8 хуралдаан 30 асуудал 25 тогтоол	12 хуралдаан 56 асуудал 53 тогтоол	1,576.4
1.2	70708	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх	Аймгийн ГЭБОНЗ нь 4 бүлэг, 21 арга хэмжээг зохион байгуулах	Төсөл, арга хэмжээний тоо Хэрэгжилт	хувь	2025	3 бүлэг, 19 арга хэмжээ, 94.7%	3 бүлэг, 13 арга хэмжээ	271.0
1.3	70709	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	Аймгийн ГХУСАЗСЗ нь 7 зорилт 47 арга хэмжээг хэрэгжүүлж гэмт хэргээс урьдчилан сэргийлж, иргэдийн аюулгүй амар тайван байдлыг хангах	Төсөл, арга хэмжээний тоо Хэрэгжилт	хувь	2025	8 бүлэг 38 арга хэмжээ, 92%	8 бүлэг 44 арга хэмжээ, 95%	1,531.0

2. Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын Газар										22,176.2
2.1	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт	хувь	2024	71.9	73	7,932.7	
2.2	70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллага, аж ахуйн нэгжийн их засварын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх	Төсөл, арга хэмжээний тоо	тоо	2025	17	8	2,411.7	
2.3	71101	Автозам	Орон нутгийн авто зам, замын байгууламжийг нэмэгдүүлэн иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ	тоо	2025	4	3	2,779.7	
2.4	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх.	Төсөл, арга хэмжээний тоо	тоо	2025	0	16	4,454.8	
2.5	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Орон нутгийн хөрөнгө сангийн хөрөнгө оруулалтаар шинээр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх.	Төсөл, арга хэмжээний тоо	тоо	2025	7	13	4,597.4	
3. Хотын захирагчийн алба										565.2
3.1	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хот байгуулалт, дэд бүтэц, тохижилт үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Төсөл, арга хэмжээний тоо Хэрэгжилт,	хувь	2024	4 арга хэмжээ 84.2%	4 арга хэмжээ 90%	565.2	

4. Засаг дарга										11,395.8
4.1	71105 72207	Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр, хүүхдийн хөгжил хамгаалал	Байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, тээврийн үйлчилгээг хөгжүүлж, нийтийн тээврийн үйлчилгээнд ухаалаг систем нэвтрүүлэн, алслагдсан гэр хорооллын чиглэлд үйлчилгээг өргөжүүлэх	Зорилгот иргэдэд үйлчилсэн нийтийн тээврийн чиглэл	Тоо	2025	13	14	4,597.6	
4.2	70425	Орон нутгийн хэвлэл мэдээлэл	1. Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцооны системийн хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэн, ашиглалтыг сайжруулах. 2. Орон нутгийн боллого үйл ажиллагааны талгаархи мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд шуурхай мэдээлгэх	Системийн хэрэглэгч тоо, мэдээлсэн мэдээний тоо	Тоо	2025	1.3274 2.1920	1.3800 2.2500	610.0	
4.3	70805	Мал аж ахуйг хөгжүүлэх	Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг технологит хугацаанд хамруулан өвчингүй тайван бүсийн статусаа хамгаалах, халдварт өвчний тохиолдлыг бууруулсан байна.	Арга хэмжээний хэрэгжилт, хамрагдсан мал	Хувь, мян.т олгой	2025	95/5	95/6	124.2	

4.4	72208	Ахмад настны хөгжил хамгаалал	Ахмад настны хөгжил хамгаалал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Ахмад настны хөгжил хамгаалалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ	тоо	2025	40	40	335.0
4.5	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Стратегийн хүнс, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх арга хэмжээг орон нутагт хувийн хэвшлийн оролцоотой зохион байгуулах	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлсэн хэмжээ	тн	2025	Өвс-100 Тэжээл-30	Өвс-80 Тэжээл-70 Эрдэс-1	132.3
4.6	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Махны эрэлт нийлүүлэлтэд тохирсон бодлого зохицуулалтаар хангана.	Нөөцийн махны хэмжээ	тн	2025	102	122	366.0
4.7	71101	Автозам	Хотын доторх зам, замын нөхөөс, арчлалт, шинэчлэлтийг гүйцэтгэн замын нөхцөл сайжирна.	Замын ан цав /Метр/Замын босоо, хэвтээ тэмдэглэгээ, замын нөхөөс хийсэн тоо, хэмжээОрлого төвлөрүүлэлт ийн хувь	м2	2024	Замын ан цав-22,070 метр Замын босоо тэмдэглэгээ -130 ш Замын хэвтээ тэмдэглэгээ -18,854 метр Замын нөхөөс-4339.4 м2 Орлого төвлөрүүлэлт-100%	Замын ан цав-24,000 метр Замын босоо тэмдэглэгээ 9-66 ш Замын хэвтээ тэмдэглэгээ 9-16,000 метр Замын нөхөөс-3250 м2 Орлого төвлөрүүлэлт-100%	1,100.0

4.8	71101	Автозам	Албан татвар, төлбөр хураах ажлыг зохион байгуулж тухайн нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгсэл эзэмшиж буй иргэн аж ахуй нэгж, байгууллагыг бүрэн хамруулж, өмнөх жилийн хамрагдалтын тоог нэмэгдүүлж орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх	Хамруулсан Авто тээврийн хэрэгсэлийн	Тоо	2024	25370	32000	5.3
4.9	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Дархан сумын нутаг дэвсгэрт 13 Байршилд 421.6 га газрыг дахин төлөвлөлтийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх	Төсөл, арга хэмжээний тоо Хэрэгжилт, хувь			15 арга хэмжээ хэрэгжилтийн дундаж хувь 85 %	16 арга хэмжээ хэрэгжилтийн дундаж хувь 88 %	280.0
4.10	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Улсын төсвийн байгууллагын албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгосон байна.	Хамрагдсан байгууллага, албан хаагчдын тоо,	тоо	2025	21 байгууллага а, 513 албан хаагч	21 байгууллага а, 490 албан хаагч	3,845.3
5. Орон нутгийн хүүхдийн зуслан амралт									
5.1	72207	Хүүхдийн хөгжил хамгаалал	Хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөгжлийн үйлчилгээнд хамруулсан байна.	Нийт хамрагдсан хүүхдийн тоо, зорилтот бүлгийн хүүхдийн тоо	Хувь	2025	Нийт -2734 зорилтот бүлгийн хүүхэд - 245	Нийт - 2800 зорилтот бүлгийн хүүхэд -250	759.5
5.2	72212	Гэр бүлийн хөгжил хамгаалал	Гэрлэх ёслолын өргөөгөөр дамжуулан гэр бүлийн боловсрол олгосон байна.	Хамрагдсан хосын тоо, сургалт, зөвлөгөө авсан иргэдийн тоо,	Хувь	2025	Хос-32, үйлчилгээ авсан иргэд-1888	Хос-40 сургалт, зөвлөгөө авсан иргэд -2360	221.4
6. Даймгийн халамжийн сан									574,3

			Дотоод аудит хийх /ЗГҮАХ 3.1.2/	Дотоод аудитад хамрагдах байгууллагын тоо	Тоо	2025	20	21	
			Шилэн дансны цахим системд дотоод хяналт тавих, тайланг Сангийн яам, Төсвийн Ерөнхийлөн захирагчид хүргэх /ЗГҮАХ 3.1.12, ЗДҮАХ 2.1.2.1/	Байршуулбал зохих мэдээ, тайлангийн үнэн зөв байдал, хугацаандаа мэдээлсэн төвшин	хувь	2025	98.7	98.8	
9. Орон нутгийн өмчийн газар									
			Төсөвт болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад төлөөлөл удирдлагыг хэрэгжүүлж, хяналт тавих, ашиглалтыг сайжруулах	Төсөвт болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний хэрэгжилт	хувь	2025	100	100	488.5
10. Худалдан авах ажиллагааны газар									
			Тухайн жилд төлөвлөгдсөн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээг зохион байгуулах	Төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	2025	17 зорилт 25 арга хэмжээ 100	17 зорилт 25 арга хэмжээ 100	517.3
11. Сум дундын ойн анги									
			Худалдан авах ажиллагаа						230.7
10.1	70418	Худалдан авах ажиллагаа							517.3

11.1	71403	Ойжуулалт	Ой хамгаалах, нөхөн сэргээх, зохицтой ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх	Төсөл, арга хэмжээний тоо	Тоо	2025	3 зорилт, 19 арга хэмжээ	3 зорилт, 15 арга хэмжээ	230.7
12. Ахмадын хөгжлийн төв									
12.1	72208	Ахмад настны хөгжил, хамгаалал	Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх / 2025-2028 оны ЗДҮАХ 1.1.2.2 /	тусламж үйлчилгээнд хамрагдах ахмадын тоо	тоо	2024	13464	14000	1,319.3
13. Мэргэжлийн боловсрол									
13.1	71804	Мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн тоог нэмэгдүүлнэ.	МСҮТ-д суралцагчид	тоо	2025	785	810	806.7
14. Биеийн тамир, спорт									
14.1	71701	Биеийн тамир, спорт	Спортын төрлөөр хичээллэгсэдийн тоог нэмэгдүүлнэ.	Спортоор хичээллэгсэд	хүн	2025	18000	19500	1,545.1
15. Соёл урлаг									
15.1	71702	Соёл урлаг	Соёл урлагийг түгээн дэлгэрүүлнэ.	Иргэдэд хүргэсэн соёл урлагийн арга хэмжээ	тоо	2025	238 арга хэмжээ 128877 хүн	240 арга хэмжээ 130000 хүн	205.0
16. Эрүүл мэнд									
16.1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан иргэд	тоо	2024	Амбулаторийн тусламж үйлчилгээ - 236,911 Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ - 16,616	Амбулаторийн тусламж үйлчилгээ - 204,700 Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ - 14,400	1,064.2

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 03 -ны өдрийн
18 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Дархан-Уул аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 оны төсвийн жилд
хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт

Д/д	Төсөл, арга хэмжээ	А	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг /мян.төг/	2026 онд санхүүжих дүн /мян.төг/
			Эхлэх	Дуусах		
1	2	3	4	5	6	7
	Засаг дарга	81			33,213,691.7	8,801,040.0
1	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	3			2,067,682.1	879,188.1
	Шилжих хөрөнгө оруулалт:2	16			7,488,253.0	3,575,624.8
	Шилжих хөрөнгө оруулалт:1	62			23,657,756.6	4,346,227.2
1.1	Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил /Дархан сумын 14-р баг/ Багц-1 мозайка шал		2021	2026		9,944.4
	Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил /Дархан сумын 14-р баг/ Багц-1 усан оргилуур	1	2021	2026	1,863,819.3	40,405.9
	Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил дугуйн зам /Дархан сумын 14-р баг/ Багц-3		2021	2026		2,448.5
1.2	Дархан 60 цогцолбор /2 үе шатны ажил/, /Сагсан бөмбөгийн талбай/	2	2022	2026	1,000,000.0	2,060.9
1.3	Анагаахын уулзвараас ШУТИС чиглэлийн авто зам дагуух дугуйн зам	3	2023	2026	171,061.0	8,550.0
1.4	Автомашинны зогсоол /Дархан сум 8-р баг/	4	2023	2026	155,000.0	7,750.0
1.5	Ногоон бүс төсөл /Дархан сум 4,5,Өргөө баг/	5	2023	2026	371,085.6	20,806.5
1.6	Мобиком-Хуучин нисэх онгоцны буудал хүртэлх автозамын трасд орсон дулааны шугамын хүчитгэл /Дархан сум 15-р баг/	6	2023	2026	62,377.4	2,714.5
1.7	Орон сууцны хороолол доторх авто замын шинэчлэл /Дархан сум, Өргөө баг/	7	2023	2026	190,000.0	13,346.7
1.8	Залуучууд театрын гадна шатны засвар /Дархан сум 14-р баг/	8	2023	2026	394,854.7	20,486.3
1.9	Тулга сувиллын барилгын засвар /Шарын гол сум/	9	2023	2026	52,000.0	3,520.4
1.10	Хуримын ордны дээвэр засвар /Дархан сум/	10	2023	2026	62,000.0	1,850.6
1.11	НОС-ны засвар /Дархан сум/	11	2023	2026	308,638.4	308,638.4
1.12	Орон сууцны байрны дээвэр сангийн засвар /Дархан сум 4-р баг, 3,4-р байр/	12	2023	2026	56,419.2	2,714.2
1.13	Замын засвар шинэчлэлт /Дархан сум 1-р баг/	13	2023	2026	14,000.0	5,886.6
1.14	Гудамж төсөл /Дархан сум 5-р баг/	14	2023	2026	14,000.0	2,278.5
1.15	Хаягжилт төсөл /Дархан сум 5-р баг/	15	2023	2026	14,000.0	2,088.2

1.16	Хог тээврийн авто машин /ДХТҮГ	16	2023	2026	104,000.0	6,625.0
1.17	Хог авах цэг байгуулах /Дархан сум 8-р баг/	17	2023	2026	84,000.0	5,150.0
1.18	Сайжруулсан зам барих ажил /Дархан сум Малчин баг/	18	2023	2026	14,000.0	2,948.8
1.19	Шороон зам шинээр барих төсөл/ Малчин баг/	19	2023	2026	14,000.0	2,948.5
1.20	Жаргалтай амьдрал төв байгуулах байрны засварын нэмэлт ажил /Дархан сум/	20	2023	2026	20,000.0	600.0
1.21	Тусгай зориулалтын авто машин /Дархан зам тээвэр ОНӨААТҮГ/	21	2024	2026	75,000.0	73,800.0
1.22	"Од" цогцолбор сургуулийн" А" байрны спорт заалны засвар	22	2023	2026	228,161.7	17,589.2
1.23	Ид шидийн орон төслийн гадна төмөр /Хашаа угсрах ажил/	23	2023	2026	24,900.4	1,235.0
1.24	Төрийн үйлчилгээний авто машин /Зш/	24	2023	2026	466,250.0	385,524.1
1.25	Болзошгүй гамшиг ослын үед ашиглах түр сууц /Онцгой байдлын газар/	25	2023	2026	41,000.0	1,100.0
1.26	Гэрэлтүүлэг /Дархан сум/	26	2023	2026	987,037.1	48,278.8
1.27	Хорооллын доторх авто зогсоол /Дархан сум 4-р баг/	27	2023	2026	158,478.48	4,684.2
1.28	Спорт заалны дээвэр засвар /Дархан сум 2200 суудалтай спорт цогцолбор/	28	2024	2026	200,000.0	10,000.0
1.29	Төв авто зам-Төмөр замын гарам-МСҮТөв хүртэлх авто /Дархан-Уул, Дархан сум/	29	2023	2026	2,811,442.7	119,542.9
1.30	Сургалтын ерөөний засвар, тоног төхөөрөмж /Прокурорын газар/	30	2024	2026	38,761.5	3,622.0
1.31	"Ногоон Дархан-2032" хөтөлбөр	31	2024	2026	500,000.0	480,000.0
1.32	Аймгийн төв доторх авто замын шинэчлэлт засварын ажлын хүрээнд буцаж эргэлт төлөвлөх /Дархан сум 5-р баг	32	2024	2026	9,606.5	9,606.5
1.33	Наадмын талбайн тохижилт	33	2024	2026	4,508.0	2,254.0
1.34	Тоглоомын орчныг сайжруулах төсөл	34	2024	2026	10,000.0	10,000.0
1.35	Спорт заалны тоног төхөөрөмж төсөл	35	2024	2026	10,000.0	10,000.0
	Төсөл хөтөлбөр /Аймгийн хэмжээнд/			2026		-
1.36	Тосгон соёл амралтын тохижилт /Дархан сум 1,2,3-р баг/	36	2024	2026	600,000.0	390,000.0
1.37	Хатуу хучилттай авто зам /Дархан сум 5-р баг/	37	2024	2026	960,000.0	1,919.2
1.38	Хог хаягдлын менежмент төсөл /Дархан сум 7-р баг/	38	2024	2026	300,000.0	16,855.8
1.39	Тохижилтын ажил /Дархан сум 8-р баг/	39	2024	2026	300,000.0	10,200.6
1.40	Төв замаас Од цогцолбор сургууль чиглэлийн авто замын өргөтгөл /Дархан сум 13,14,16-р баг/	40	2024	2026	585,000.0	17,550.0
1.41	"Ногоон бүс төсөл -3" /Дархан сум 10-р баг/	41	2024	2026	200,000.0	14,303.9
1.42	Цахим Дарханы үлдэгдэл	42	2023	2026	369,000.0	18,450.0
1.43	Оргил худалдааны төв-Шинэ авто зам хүртэлх нэмэлт 48м авто замын ажил /Дархан сум 8-р баг/	43	2024	2026	304,762.3	259,000.0
1.44	Автомашин зогсоол /Нэгдсэн эмнэлэг/	44	2024	2026	418,500.0	83,700.0
1.45	8 дугаар багийг 1 багтай холбосон гүүрэн гарцын дэргэдэх авто замын ус зайлуулах систем /Дархан сум 8-р баг/	45	2024	2026	241,215.7	241,215.7
1.46	Авто зогсоол /Дархан сум 14-р баг/	46	2024	2026	246,770.5	12,400.0

1.47	Дэд бүтэц шинээр татах /Дархан сум 1-р баг/	47	2024	2026	834,942.4	18,476.3
	Боловсрол-2032 хөтөлбөр III үе шат					-
1.48	9-р сургуулийн спорт заалны цонхны засвар /Дархан сум 11,12-р баг/	48	2024	2026	68,061.8	3,403.1
1.49	СӨБ, ЕБС-ын засвар, үйлчилгээ, тоног төхөөрөмж	49	2024	2026	279,881.1	10,364.6
1.50	Дархан 60 цогцолборын экстрем тоглоомын талбайг асфальтбетон болгох ажил	50	2024	2026	81,000.0	40,500.0
1.51	Удирдлагын нэгдсэн систем төв байгуулах /Цагдаагийн газар/	51	2024	2026	1,874,376.1	94,000.0
1.52	Шуурхай удирдлагын төвийн тоног төхөөрөмж /Онцгой байдлын газар/	52	2024	2026	140,380.0	4,211.4
1.53	Үений дурангийн мэс заслын тоног төхөөрөмж	53	2024	2026	598,000.0	29,900.0
1.54	Хорооллын доторх авто замын шинэчлэлт /Дархан сум 4-р баг, 5-р байр/	54	2025	2026	336,686.7	59,195.3
1.55	Авто замын шинэчлэлт /Дархан сум 5-р баг/	55	2025	2026	315,270.9	107,745.0
1.56	Бурхантай толгойн авто машины зогсоол /Дархан сум 8-р баг/	56	2025	2027	498,864.3	147,445.8
1.57	Авто зогсоол /Дархан сум 9-р баг, 4/7-р байрны ард/	57	2025	2026	493,277.3	119,768.6
1.58	Багш хөгжлийн төвийн гаднах автомашины зогсоол /Дархан сум 11-р баг/	58	2025	2026	198,584.1	62,445.8
1.59	Авто зам дагуух явган замын ажил /Дархан сум, Өргөө баг/	59	2025	2026	203,246.5	13,549.2
1.60	15-р багийн дулаан хангамжийн шугамыг 31-р хорооллын дулаан хангамжтай холбох тойрог схемд оруулах	60	2025	2026	1,545,915.9	284,904.4
1.61	Ногоон бүс төсөл /Дархан сум 8,9,11,12-р баг/	61	2025	2026	999,792.6	499,896.3
1.62	Зураг төсөв боловсруулах /Аймгийн хэмжээнд/	62	2025	2026	133,826.6	133,826.6
2	Шилжих хөрөнгө оруулалт:2	16			7,488,253.0	3,575,624.8
2.1	Төрийн үйлчилгээний авто машин /Зш/	1	2023	2026	466,250.0	80,725.9
2.2	"Ногоон Дархан-2032" хөтөлбөр	2	2024	2026	500,000.0	20,000.0
2.3	Тосгон соёл амралтын тохижилт /Дархан сум 1,2,3-р баг/	3	2024	2026	600,000.0	210,000.0
2.4	Оргил худалдааны төв-Шинэ авто зам хүртэлх нэмэлт 48м авто замын ажил /Дархан сум 8-р баг/	4	2024	2026	304,762.3	45,762.3
2.5	Хорооллын доторх авто замын шинэчлэлт /Дархан сум 4-р баг, 5-р байр/	5	2025	2026	336,686.7	277,491.4
2.6	Авто замын шинэчлэлт /Дархан сум 5-р баг/	6	2025	2026	315,270.9	207,525.8
